



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/132

Зуунмод

Аймгийн хэмжээнд 2024 онд
зохион байгуулах эрх зүйн сургалт
сурталчилгааны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2024 онд зохион байгуулагдах эрх зүйн сургалт сурталчилгааны ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тайлан мэдээг заагдсан хугацаанд ирүүлэн ажиллахыг хэлтэс, агентлаг, байгууллагын дарга, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (С.Магнайбаяр)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 04 -ны өдрийн 41/32 дүгээр захирамжийн хавсралт

2024 ОНД АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хугацаа	Төсөв (мян. төг)	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
Нэг. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд								
1	Сумдын "Иргэний танхим"-ын үйл ажиллагааг тогтмолжуулж, сар тутамд хууль сурталчлах нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж хэвшүүлэх, сургалт сурталчилгааны ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.	Сургалт зохион байгуулах	Иргэний танхимаас сар тутамд өдөрлөг зохиож хууль сурталчилж хэвшүүлсэн байна. Иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн байна.	Иргэдийн оролцоо сайжирч сургалт мэдээллийн ажлын хэмжээ, чанар сайжирна.	Жилдээ	-	Сумдын Засаг даргын Тамгын газар	Хууль, эрх зүйн хэлтэс
2	Багийн иргэдийн Нийтийн Хурал багийн өдөрлөгийн үеэр сумдын төрийн албан хаагчид хариуцсан салбарын хүрээнд тодорхой сэдвээр тухай бүр сургалт сурталчилгаа хийх.	Сургалт зохион байгуулах	Жилд 4-өөс доошгүй удаа 3-оос доошгүй сэдвээр хийсэн байна.	Иргэдэд хүргэх мэдээллийн хүртээмж сайжирна.	Улирал бүр	Орон нутгийн төсөв	Сумдын Засаг даргын Тамгын газар	Хэлтэс, агентлаг, байгууллагууд
3	Эрх зүйн хөтөч бэлтгэх, давтан сургах сургалтыг цахим болон танхим хослогсон хэлбэр зохион байгуулах.	Сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдсан эрх зүйн хөтчийн тоо	Эрх зүйн хөтчийн сургалт зохион байгуулагдсан байна	2,3 улиралд	Орон нутгийн төсөв	Хууль, эрх зүйн хэлтэс	Хууль зүйн үндэсний хүрээлэн
4	Төрийн албан хаагчдад захиалгат болон төлөвлөгөөт сургалтыг тухай бүр зохион байгуулах.	Сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан арга хэмжээний тоо	Төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна	Жилдээ	-	Сумдын Засаг даргын Тамгын газар,	Хууль, эрх зүйн хэлтэс

5	Эрх зүйн хөтчийн булант идэвхтэй ажиллуулах.	Мэдээлэл	Иргэдийн эрх зүйн мэдээлэл авах боломж бүрэн бүрдсэн байна.	Иргэдэд мэдээллийг шуурхай хүртээмжтэй байдлаар хүргэнэ.	Жилийн турш	-	Сумдын Засаг даргын Тамгын газар	Хэлтэс, агентлаг, байгууллагууд
6	Эрх зүйн хөтөч нарыг хууль тогтоомжийн эмхтгэл гарын авлагаар хангах.	Гарын авлага	Хэрэгцээ, шаардлагад нийцсэн гарын авлагаар хангасан байна.	Эрх зүйн хөтчийн үйл ажиллагаа явуулах боломж хангагдсан байна.	Жилийн турш	-	Хууль, эрх зүйн хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар
7	Иргэн бүрийн мэдвэл зохиох хууль тогтоомж, эрх зүйн актын гарын авлага материал бэлтгэж, сүм багийн иргэдэд хүргэх.	Гарын авлага	Хэрэгцээ, шаардлагад нийцсэн гарын авлагаар хангасан байна.	Гарын авлага материал бэлтгэн иргэдэд хүргэнэ.	Жилдээ	-	Хууль, эрх зүйн хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар
Хоёр. Аймаг сүм баг байгууллагууд болон иргэдийн дунд явуулах сургалт сурталчилгааны ажлын хүрээнд								
8	Сумдыг бүсчлэн иргэдэд хууль хяналтын байгууллагатай хамтарсан хууль сурталчлах өдөрлөг зохион байгуулах.	Өдөрлөг зохион байгуулах	Тусгай хөтөлбөрөөр иргэдэд шаардлагатай хууль тогтоомжоор явуулах	Иргэдэд хүргэх эрх зүйн мэдээлэл нэмэгдэнэ.	2,3 улиралд	Орон нутгийн төсөв	Хууль, эрх зүйн хэлтэс	Хууль хяналтын байгууллага
9	Сар бүр тодорхой нэг салбарын хуулийг сурталчлах аян зохион байгуулах.	Сургалт, өдөрлөг зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан арга хэмжээний тоо	Эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг шинэлэг сонирхолтой хүртээмжтэй арга хэлбэрээр иргэдэд хүргэж, цар хүрээг өргөжүүлнэ.	Жилдээ	Орон нутгийн төсөв	Сумдын Засаг даргын Тамгын газар	Хэлтэс, агентлаг, байгууллагууд
10	Тухайн жилд шинээр батлагдсан хууль, тогтоомж шийдвэрийн жагсаалтыг гаргаж иргэдэд олон талт хэлбэрээр сурталчилгах.	Сургалт, постер, подкаст	Жагсаалт гаргаж, сургалт сурталчилгаа зохион байгуулсан тоогоор	Иргэд зайлшгүй мэдвэл зохиох хууль тогтоомжийн мэдээлэлтэй болно.	Жилдээ	-	Сумдын Засаг даргын Тамгын газар	Хэлтэс, агентлаг, байгууллагууд

11	Төрийн албан хаагчдад таниулах шаардлагатай хууль тогтоомж, дүрэм журмуудыг олон талт хэлбэрээр сурталчилгах.	Сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан арга хэмжээний тоо	Төрийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэг дээшилнэ.	Жилдээ	-	Сумдын Засаг даргын Тамгын газар	Хэлтэс, агентлаг, байгууллагууд
12	Хууль зүйн туслалцааны төвийн Төв аймаг дахь салбартай хамтран иргэдэд сургалт зохион байгуулж, зөвлөгөө, мэдээлэл өгөх.	Сургалт зохион байгуулах	Зуунмод, Батсүмбэр, Сэргэлэн сумдын иргэдэд зохион байгуулж, эрх зүйн зөвлөгөө өгсөн байна.	Зуунмод, Батсүмбэр, Сэргэлэн сургалт зохион байгуулагдсан байна.	2,3 улиралд	-	Хууль зүйн туслалцааны төвийн Төв аймаг дахь салбар	Хууль, эрх зүйн хэлтэс
13	Сонгуулийн тухай хууль, холбогдох дүрэм журмуудыг олон талт хэлбэрээр сурталчилгах.	Сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан арга хэмжээний тоо	Иргэдийн сонгуулийн тухай хууль тогтоомжийн мэдлэг дээшилнэ.	2,3 улиралд	-	Сумдын Засаг даргын Тамгын газар	Хууль, эрх зүйн хэлтэс
Гурав. Хууль, эрх зүйн сургалт мэдээллийн ажлын чиглэлээр хийгдэх бусад ажлын хүрээнд								
14	Хууль зүйн постер, подкаст бэлтгэж, олон нийтэд түгээх.	Постер, подкаст	Постер, подкаст бэлтгэж, олон нийтэд түгээсэн байна	Иргэд хууль тогтоомжийн мэдээлэлтэй болно.	Жилийн турш	-	Хууль, эрх зүйн хэлтэс	Хэлтэс, агентлаг, байгууллагууд
15	Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан иргэнд өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх.	Тайлан, мэдээ	Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх тоо нэмэгдсэн байна	Иргэдэд эрх зүйн үйлчилгээг хүргэсэн байна.	Жилдээ	-	Хууль зүйн туслалцааны төвийн Төв аймаг дахь салбар	Хууль, эрх зүйн хэлтэс
16	Эрх зүйн цахим системийг нэвтрүүлэх	Цахим программ	Цахим программ нэвтрүүлсэн байна.	Цахимаар иргэд болон төрийн албан хаагчдад хууль эрх зүйн мэдээлэл хүргэсэн байна.	Жилдээ	-	Хууль, эрх зүйн хэлтэс	-
17	Аймаг сумдын эрх бүхий албан тушаалтны захиргааны акт, захиргааны хэм хэмжээ	Захиргааны акт, хэм хэмжээ тогтоосон акт	Шийдвэрийг цэгцлэх ажил зохион	Аймаг сумдын хэмжээнд мөрдөгдөх эрх	Жилдээ	-	Хууль, эрх зүйн хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар

ТОГТООСОН ШИЙДВЭРҮҮДЭД ХЯНАЛТ шинжилгээ үнэлгээ хийх		байгуулж, захиргааны акт, хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн бичмэл санг сүүлийн 10 жилээр бүрдүүлэх	зүйн актуудыг иргэд мэдэх боломжтой болно.					
---	--	---	---	--	--	--	--	--

ХЯНАСАН
 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
 ДАРГА  С. МАГНАЙБАЯР
 БОЛОВСРУУЛСАН 
 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
 МЭРГЭЖИЛТЭН  Г. ОЮУН-ЭРДЭНЭ